

АЖ ТОРОХ
УХААН

Г.Ловор

ШИЙДВЭР



3-р
ангийнханд
зориулав

**Г.Ловор
Шийдвэр**

Бага сургуулийн 3-р ангийн сурагчдад зориулав.

Зураач	Л.Зулбадрах
Хянан тохиолдуулагч	Д.Сугархүү
Хянагч	О.Мөнхтуяа
Хэвлэлийн эх бэлтгэсэн	Ж.Гэрэлмаа
	Н.Хөдөлмөр
	Д.Хишигдэлгэр



Хэвлэн нийтлэлийг Интерпрес ХХК

2007 он

ШИЙДВЭР

Сургуулийн зуны амралт эхэллээ. Аав намайг бага сургуулиа амжилттай дүүргэлзээ гэж толгой илэв. Тэр нь надад их сайхан санагдлаа.




Ээж намайг үнсээд,

- Дуртай юмаа ав даа! Гээд 500-тын дэвсгэрт ёгев. Үүнд надаас илүү дүү минь баярлав. Бодвол тэр мэнгөөр чихэр худалдан авч, хувааж иднэ гэж санасан бололтой.

Бид хоёр юутай ч гадагшаа гарлаа. Хэд алхав уу үгүй ю,

- Зайрмаг аваарай гэх дуу чих дэлдэв. Дүү,

- Шоколадтайг нь аваарай, амттай шүү гээд шүлсээ залгина.



- Зайрмаг аваад яах юм. Идээд л дуусчихна шүү дээ.

- Тэгээд юу авах гэж?

- Юу ч гэсэн дэлгүүрээр орьё гэсэнд тэр гуяа алгадах нь холгүй баярлав.

Эрээн мяраан бараан дундуур тэр намайг дагуулж явсаар тоглоомын тасаг дээр авчрав.

- Усан буу ч ёстой догъ дое.
- Яах юм, ямар жаахан хүүхдүүд биш, тэгээд ч аав "Хүн амьтан уруу чиглүүлдэг тоглоом тусгүй" гэдэг шүү дээ гэвэл тэр тавиур луу "Хүүхэлдэй" гэж заалаа. Үүнийг анзаарсан худалдагч,
- Ямар хүүхэлдэй авах вэ? Алхдаг, дуугардаг ч байна, энгийн хямдхан нь ч байна гээд үзүүлэх гэв.



- Бид хүүхэлдэй авахгүй гээд намайг цааргалсандаа.

- Өө ямар өөдгүй юм бэ? гээд дурамжхан эргэв.

- Ах тэгээд юу авах гээд байгаа юм бэ? гэж намайг зэмлэнгүй харж байна.

- Юу авахаа бодьё л доо.

- Бодоод байх юу байсан юм. Би бол энэ бөмбөгийг ч юм уу авчихна.



- Эмэгтэй хүн хөл бөмбөгөөр тоглодог юм уу?
Ашигтай л юм авья.

- Тэгвэл чихэр авч идэх ашиггүй гэж үү?

- Идээд л дордоо дуусчихна шүү дээ. Дараа нь юу ч үлдэхгүй.

- Тэгвэл оймс авах уу?

- Тэр чинь харин... гэтэл тэр намайг барааны дэлгүүр лүү хөтлөв.

Гэвч дэлгүүрт ороод оймс авах ч нэг л тусгүй санагдаад тэндээс гарлаа. Гудамжинд нэг ядуу байрын хүүхэд сууж байв. Дэргэд нь очвол,


- Та хоёр ном авч уншихгүй юу? гээд халтартсан хэдэн номоо заав.



“Шилж сонгохын үнэ цэнэ” гэсэн ном миний нүдэнд тусав. Хуудсыг эргүүлж үзвэл “сонголтоо зөв хийж чадвал та хожно” гэсэн үг дурайна.

Би тэр дороо, тэр номыг авахаар шийдэхэд дүү маань дурамжхан байв. Харин надад алдаагүй санагдлаа. Та нар юу гэж бодож байна?

Бага сургуулийн 3-р ангийнханд зориулав.



Хүн өөрөө төдийгүй өрөөл олон түмний хүчээр ажиллах, амьдрах орчин ахуйгаа хамтран бүтээдэг.



Хүний гол хүнс талх, боов хамт олны хүч хөдөлмөрөөр буй болдог.



Байгууллага хүмүүсийн хоорондын харилцан үйлчилгээ бол нийтээр тохиолог амьдрах, аж төрөх, улмаар нийгэм хөгжих боломж бүрдүүлдэг.



Зах зээлийн эдийн засгийн нөхцөлд бизнес эрхлэгч хэн ч бай, түүний үр ашгийг урьдчилан тооцоолж, сонголтоо зөв хийх нь чухал.



Дэлхийн банктай хамтран хэрэгжүүлж буй "Хөдөөгийн боловсролыг дэмжих (READ) төсөл"-ийн хүрээнд хэвлэв.
Худалдахыг хориглоно.